



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 10/285

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.5, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн 1.2, 1.10, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.7.3.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хэнийг ч ардаа бүү үлдээ” гэсэн утга санааг агуулж, дауны хам шинжтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, эрх тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоохыг уриалсан сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 2,460,700 (хоёр сая дөрвөн зуун жаран мянга долоон зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0445

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 0135 дугаар захирамжийн хавсралт

СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Найруулагчид олгох урамшуулал	1	1,000,000	1,000,000
2.	Уран зураг	1	220,000	220,000
3.	Уран бүтээлчдийн буудлын зардал	Бүтэн люкс өрөө	2 өдөр 200,000	400,000
		Хагас люкс өрөө	2 өдөр 2 өрөө 150,000	600,000
4.	Тайз, дэлгэц засах зардал	-	-	240,700
Нийт зардал				2,460,700

-oOo-